

Агуулга

	Хуудас
Банкны талаарх мэдээлэл	1
Хараат бус аудиторын дүгнэлт	2-5
Санхүүгийн байдлын тайлан	6
Орлогын дэлгэрэнгүй тайлан	7
Өмчийн өөрчлөлтийн тайлан	8
Мөнгөн гүйлгээний тайлан	9
Санхүүгийн тайлангийн тодруулгууд	10-51

“ЧИНГИС ХААН БАНК” ХХК
Банкны талаарх мэдээлэл

Үүсгэн байгуулах шийдвэр	ЧИНГИС ХААН БАНК ХХК (цаашид “Банк” гэх) нь “Арилжааны банкны үйл ажиллагаа” эрхлэн явуулах зорилгоор 2001 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн А-376 дугаар шийдвэрээр анх үүсгэн байгуулагдсан.	
Гэрчилгээ ба лиценз	Банк нь 2001 оны 6 дугаар сарын 27–ны өдөр Улсын Бүртгэлийн Албанд бүртгүүлж арилжааны банкны үйл ажиллагаа эрхлэх 2698072 тоот регистрийн дугаартай 9016001003 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээ олгогдсон	
Тусгай зөвшөөрөл	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2003 оны 10 сарын 31-ний өдрийн 556 тоот тушаалын дагуу 21 тоот банкны үйл ажиллагаа эрхлэх Банкны Зөвшөөрлийн Гэрчилгээ анх авсан.	
Салбар	<p>Охин компани “СТАНДАРТ ПАРТНЕРС” ХХК нь “Гадаад худалдаа”-ны үйл ажиллагаа эрхлэн явуулах зорилгоор Монгол улсын бүртгэлийн ерөнхий газраас 2013 оны 4 дүгээр сарын 17 –ны өдөр 5699371 тоот регистрийн дугаар бүхий 9011406086 тоот Улсын бүртгэлийн гэрчилгээг авсан байна.</p> <p>Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 149 дүгээр тушаалаар Дархан-Уул аймагт 1 салбар нээсэн.</p>	
Төлөөлөн удирдах зөвлөл	Я.Түвдэндорж Ш.Бүтэд Ц.Баярсайхан Д.Батаа Д.Чимэддагва	ТУЗ-ийн дарга ТУЗ-ийн гишүүн ТУЗ-ийн гишүүн ТУЗ-ийн гишүүн Хараат бус гишүүн
Гүйцэтгэх удирдлага	С.Сандагдорж Я.Түвдэндорж Н.Амгалан Г.Батбаяр Д.Сүхбаатар Г.Дашзэвгэ Ц.Ганзориг	Гүйцэтгэх захирал Ерөнхий захирал Гүйцэтгэх захирлын орлогч Санхүү хариуцсан дэд захирал Бизнес хариуцсан захирал Эрсдэл хариуцсан захирал Хөрөнгө оруулалт хариуцсан захирал
Хаяг	<p>Оффис 1: Монгол улс, Улаанбаатар хот, Чингисийн өргөн чөлөө - 15, Нью Сенчюри Плаза 1 ба 5 дугаар давхар</p> <p>Оффис 2: Сүхбаатар дүүргийн 1-р хороо, 13-р хороолол, Нарны зам гудамж, 62 дугаартай барилгын А блокын 9 давхар</p>	

Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2017 оны 12 сарын 31	2016 оны 12 сарын 31
Хөрөнгө			
<i>Эргэлтийн хөрөнгө</i>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4	86,319,376	45,910,415
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	5	36,598,515	15,481,849
Хөрөнгө оруулалт	6	40,653,321	44,263,890
Зээл	7	204,290,836	148,515,203
Бусад санхүүгийн хөрөнгө	8	2,686,874	323,281
Бусад санхүүгийн бус хөрөнгө	9	11,717,398	1,198,418
Үндсэн хөрөнгө	10	16,100,608	13,545,486
Биет бус хөрөнгө	11	667,477	188,925
Нийт хөрөнгө		<u>399,034,405</u>	<u>269,427,467</u>
<i>Өр төлбөр ба эздийн өмч</i>			
Харилцах	12	139,805,140	56,729,394
Хадгаламж	12	77,591,149	49,857,014
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	13	111,454,118	89,083,412
Бусад эх үүсвэр	14	35,714,275	48,563,323
Бусад санхүүгийн өр төлбөр	15	1,449,413	921,052
Бусад санхүүгийн бус өр төлбөр	16	20,344	9,633
Нийт өр төлбөр		366,034,438	245,163,828
<i>Эздийн өмч</i>			
Хувь нийлүүлсэн хөрөнгө	17	47,983,740	39,373,246
Нэмж төлөгдсөн капитал	17	0.1	0.1
Дахин үнэлгээний нэмэгдэл	17	3,400,000	-
Хуримтлагдсан ашиг	17	(18,383,774)	(15,109,607)
		<u>32,999,966</u>	<u>24,263,639</u>
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		<u>399,034,405</u>	<u>269,427,467</u>

Уг санхүүгийн тайланг 2018 оны 03 дугаар сарын 29-ний өдөр батлав:

С.Сандагдорж
Гүйцэтгэх захирал

Г.Батбаяр
Санхүү хариуцсан захирал

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2017 оны 12 сарын 31	2016 оны 12 сарын 31
Хүүний орлого		29,570,149	22,815,061
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	18	393,146	948,311
Үнэт цаасны	18	2,499,209	2,781,222
Зээлийн	18	26,453,223	14,880,733
Бусад хүүний орлого	18	224,570	4,204,794
Хүүний зардал		24,720,169	16,275,430
Харилцахад төлсөн хүү	19	7,169,607	849,701
Хадгаламжинд төлсөн хүү	19	15,827,064	4,651,344
Зээлийн хүүний зардал	19	1,166,193	1,629,644
Үнэт цаасны хүүний зардал	19	548,566	2,211,688
Бусад хүүний зардал	19	8,739	6,933,053
Хүүийн цэвэр орлого		4,849,980	6,539,630
Эрсдэлийн сангийн зардал		826,095	800,785
Үнэт цаасны	20	-	100,000
Зээлийн	20	826,095	700,785
Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого		4,023,886	5,738,846
Бусад орлого		6,228,230	23,323,085
<i>Хүүний бус орлого</i>		5,653,037	23,114,806
Арилжааны орлого	21.1	1,431,786	1,666,594
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого	21.2	1,727,457	18,509,415
Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	21.3	2,093,440	2,938,528
Бусад хүүний бус орлого	21.4	400,354	269
<i>Бусад орлого, олз</i>	21.4	575,193	208,279
Бусад зардал		13,526,282	26,835,471
<i>Хүүгийн бус зардал</i>		13,002,706	26,566,020
Бусад эрсдэлийн сангийн зардал	20	-	346,414
Арилжааны зардал	21.1	2,393,402	1,094,645
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал	21.2	1,167,928	17,953,698
Хураамж, шимтгэлийн зардал	21.3	191,346	176,439
Үйл ажиллагааны бусад зардал	22.1	9,250,030	6,994,825
<i>Бусад зардал, гарз</i>	22.2	523,577	269,451
Татварын өмнөх ашиг, алдагдал		(3,274,167)	2,226,460
Орлогын татварын зардал	23	-	1,487
Татварын дараах ашиг, алдагдал		(3,274,167)	2,224,973

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг/(алдагдал)	Нийт
2016 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	39,373,246	0.1	-	(17,334,580)	22,038,666
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн					
Алдаа	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	39,373,246	0.1	-	(17,334,580)	22,038,666
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	-	2,224,973	2,224,973
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	39,373,246	0.1	-	(15,109,607)	24,263,639
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн					
Алдаа	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	39,373,246	0.1	-	(15,109,607)	24,263,639
Ногдол ашиг	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	-	(3,274,167)	(3,274,167)
Өмчид гарсан өөрчлөлт	8,610,494	-	3,400,000	-	12,010,494
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	47,983,740	0.1	3,400,000	(18,383,774)	32,999,966

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно

Мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31	2016 оны 12 сарын 31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	-	-
Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал)	(3,274,167)	2,226,460
Орлого, зардлын тохируулга:	5,098,002	(5,118,888)
Эрсдэлийн сангийн зардал (+)	9,154,338	1,147,198
Элэгдэл, хорогдлын зардал (+)	470,654	240,347
Хуримтлуулсан хүүгийн орлого (-)	(29,570,149)	(22,815,061)
Хуримтлуулсан хүүгийн зардал (+)	24,720,169	16,275,430
Хөрөнгө данснаас хассаны олз (-), гарз (+)	147,132	33,198
Бусад олз (-), гарз (+)	175,859	-
Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн тохируулга:	36,639,012	17,804,708
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	(21,225,564)	(2,635,390)
Арилжааны үнэт цаасны өсөлт (-), бууралт (+)	3,610,569	(32,710,327)
Зээлийн өсөлт (-), бууралт (+)	(53,734,030)	14,223,317
Бусад санхүүгийн хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	(2,363,593)	(576,652)
Бусад санхүүгийн бус хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	(10,518,980)	335,798
Харилцах, хадгаламжийн өсөлт (+), бууралт (-)	110,809,880	18,119,882
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн өсөлт (+), бууралт (-)	9,521,658	20,723,289
Бусад санхүүгийн өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	528,361	344,736
Бусад санхүүгийн бус өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	10,711	(19,946)
Бусад тохируулга:	676,686	1,688,911
Авсан хүү (+)	26,045,530	17,582,494
Төлсөн хүү (-)	(25,368,845)	15,863,556
Орлогын татварын төлөлт (-)	-	30,027
Эрсдэлийн сангаас хаасан зээл, авлага (-)	-	-
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	39,139,532	16,601,191
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	-	-
Мөнгөн орлогын дүн (+)	5,930,086	282,640
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	5,930,086	282,640
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө борлуулсны орлого	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	(4,660,659)	(10,065,807)
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(4,122,505)	(10,038,466)
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(538,154)	(27,342)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,269,428)	(9,783,167)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	40,408,960	6,818,023
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	45,910,415	39,092,392
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	86,319,376	45,910,415

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно

Санхүүгийн тайлангийн тодруулгууд

1 Үйл ажиллагааны онцлог, ерөнхий мэдээлэл

“ЧИНГИС ХААН БАНК” ХХК (“Банк”) нь Британийн Виржини Арлуудын “Миллениум Секьюритис Менежмент Лимитед” компанийн 2001 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн шийдвэр, Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн даргын 2001 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн А-376 тоот тушаалаар гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр Монгол улсад үүсгэн байгуулагдсан. Гадаадын Хөрөнгө Оруулалттай Аж Ахуйн Нэгжийн 01-165 тоот гэрчилгээ авсан.

Монгол улсын “Банкны тухай” хуулийн дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 556 тоот тушаал, Монголбанкнаас олгосон 21 дүгээр Банкны зөвшөөрлийн гэрчилгээгээр тус банкинд банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.

Энэхүү шийдвэрээр банк нь зээл, төлбөр, тооцоо, гадаад валют худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах, үнэт зүйл хадгалах, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөмж, мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан.

Улмаар банкинд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2004 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 630 тоот тушаалаар “зөвхөн гадаадын харьяат иргэд, байгууллагад мөнгөн хадгаламжийн үйлчилгээ үзүүлэх, өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд батлан даалт гаргах, үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах, Монголбанктэй зөвшилцсөний үндсэн дээр үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2005 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 124 тоот тушаалаар “Зөвхөн өөрийн зээлдэгчдийн хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагын хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх” зөвшөөрлийг тус тус олгосон.

Банкны хувь нийлүүлэгчийн 2003 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн шийдвэрээр банкнаас нэмж гаргасан хувьцааг Британийн Виржини Арлуудын “Корал Си Холдинг Групп” компанид худалдсанаар банкны хувьцааг “Миллениум Секьюритис Менежмент Лимитед” компани, “Корал Си Холдинг Групп” компани хувь тэнцүү хэмжээгээр эзэмших болсон.

2015 онд “ЧИНГИС ХААН БАНК” ХХК-ийн хувьцаа эзэмшигч болох Миллениум Секьюритис Менежмент Лимитед компани болон Корал Си Холдинг Групп компаниудын бүтцийн өөрчлөлтийн дагуу банкны хувьцааг Корал Си Холдинг Групп 100% эзэмшиж, Корал Си Холдинг Группийн хувьцааг Миллениум Секьюритис Менежмент Лимитед компани 100% эзэмшихээр болсон. Миллениум Секьюритис Менежмент Лимитед компани нь Корал Си Холдинг Группийн хувьцааг Монгол улсын Ньюстандарт Финанс ХХК-д шилжүүлсэн байна.

Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-36.3 дахь заалт, Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц өөрчлөлт оруулах зөвшөөрлийн шаардлагыг хангасан тул Монголбанкны 2017 оны 8 дугаар сарын 16-ны А-1а/857 дугаар тоотой 0.63 тэрбум төгрөгөөр, 2017 оны 12 дугаар сарын 28-ны А-1/1382 дугаар тоотой “Ньюстандарт Финанс” ХХК-д иргэн Д.Батаа 4.0 тэрбум төгрөгөөр, Ш.Бүтэд 3.98 тэрбум төгрөгөөр, нийт 8.61 тэрбум төгрөгөөр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн байна.

Банкны ажилтнуудын тоо 2017 онд дунджаар 176 орчим байсан байна.

Банк нь Улаанбаатар хотод төв салбар, Дархан-Уул аймагт 1 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

2 Санхүүгийн тайлан бэлтгэх суурь

2.1 Үндсэн зарчим

Банкны эдгээр санхүүгийн тайлангууд нь Монголбанкны Ерөнхийлөгчийн 2003 оны 549 тоот тушаалаар баталсан Банкны нягтлан бодох бүртгэлийн үлгэрчилсэн заавар, журам, аргачлал болон арилжааны банкинд мөрдүүлэхээр баталсан бусад журам, зааврын дагуу бэлтгэгдсэн.

Банк нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу нягтлан бодох бүртгэлээ хөтөлдөг.

2.2 Хэмжилтийн суурь

Эдгээр санхүүгийн тайланг ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн хөнгөлөгдсөн үнэ цэнээр илэрхийлэгдсэн тодорхой санхүүгийн хэрэглүүр болон дахин үнэлсэн дүнгээр илэрхийлсэн тодорхой үндсэн хөрөнгөөс бусдаар түүхэн өртгийн сууриар бэлтгэсэн.

2.3 Үйл ажиллагааны ба толилуулгын валют

Эдгээр санхүүгийн тайлангууд нь банкны гүйлгээний болон тайлагналын валют болох Монгол улсын Үндэсний Төгрөг (“төгрөг”)-өөр илэрхийлэгдсэн ба өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд бүх үзүүлэлтүүдийг мянгачлан илэрхийлсэн.

2.4 Тооцоолол ба үнэлэмжийн хэрэглээ

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь удирдлагаас санхүүгийн тайлангийн өдрөөр тайлагнасан хөрөнгө, өр төлбөрийн дүн болон тайлант хугацааны орлого, зарлагын тайлагнасан дүнд нөлөөлөх чухал таамаглал тооцоолол хийхийг шаарддаг. Эдгээр тооцоолол нь тухайн үйл явдал, үйл ажиллагааны талаарх удирдлагын хамгийн сайн мэдлэг дээр суурилсан байдаг боловч, бодит үр дүн нь эцсийн дүндээ эдгээр тооцооллоос өөр байж болох бөгөөд анхны тооцоолол, түүний таамаглалыг тухайн нөхцөл байдал, тухайн жилд нь тохируулан өөрчилж болно.

2.5 Шинэ болон засварлагдсан стандартын хэрэглээ

Банк нь Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайдын 2015 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн А35/20 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулгыг мөрддөг.

Тайлант онд Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын зөвлөл (НББОУСЗ) болон СТОУС-ын Тайлбарын хороо (СТОУСТХ)-ноос гаргасан санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 2016 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш хүчин төгөлдөр үйлчлэх бүх шинэ болон нэмэлт өөрчлөлт орсон Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт (СТОУС)-ыг дээрх журамд оруулах хүртэл банк хэрэгжүүлэхгүй.

Эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийн талаар товч мэдээллийг дор харуулав.

2016 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш хүчин төгөлдөр үйлчилж буй шинэ болон нэмэлт өөрчлөлт орсон Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт түүний тайлбарууд

*НББОУС 16 “Үндсэн хөрөнгө”, НББОУС 38 “Биет бус хөрөнгө”-ийн нэмэлт өөрчлөлтүүд:
Элэгдэл ба хорогдлын хүлээн зөвшөөрөгдөх аргуудын тодруулга*

Энэхүү өөрчлөлтөөр орлого нь хөрөнгийг ашиглаж буй үйл ажиллагаанаас бий болсон орлогод тухайн хөрөнгийн эдийн засгийн үр өгөөжийн ашиглалтаас илүү бизнесийн үйл ажиллагаанаас бий болсон эдийн засгийн үр өгөөжийн загварыг харуулдаг гэдгийг НББОУС 16 болон НББОУС 38-д оруулж өгсөн. Үүний үр дүнд орлогод суурилсан аргыг үндсэн хөрөнгөд ашиглахгүй бөгөөд биет бус хөрөнгийг хорогдуулах хязгаарлагдмал нөхцөл байдалд хэрэглэнэ.

НББОУС 27 Тусдаа санхүүгийн тайланд орсон нэмэлт өөрчлөлт-Тусдаа санхүүгийн тайлан дахь өмчийн арга

Энэхүү нэмэлт өөрчлөлтөөр аж ахуйн нэгж нь тусдаа санхүүгийн тайландаа охин компани, хараат компани, хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалтыг өмчийн аргаар бүртгэх боломжтой болсон. Аж ахуйн нэгж нь өмнө нь СТОУС-ыг хэрэглэж байгаад тусдаа санхүүгийн тайлангаа өмчийн аргаар өөрчлөх болсон бол өөрчлөлтийг буцаах замаар хэрэглэнэ. Тусдаа санхүүгийн тайландаа өмчийн аргыг ашиглахаар сонгон СТОУС-ыг анх удаа хэрэглэх гэж буй этгээдийн хувьд СТОУС-д хөрвүүлсэн өдрөөс эхлэн энэхүү аргыг хэрэглэхийг шаардана.

Жилийн сайжруулалтууд 2012-2017

2012-2017 оны жил бүрийн сайжруулалт хэсэгт хэд хэдэн СТОУС-тай холбогдуулан зарим жижиг өөрчлөлтүүд орсон. Банкинд хамаарах өөрчлөлтүүдийг дор харуулав. Үүнд:

СТОУС 5 “Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба Зогсоосон үйл ажиллагаа”

Аж ахуй нэгж нь хөрөнгийг (данснаас хасах зүйл) цаашид шууд хуваарилах боломжгүй эсвэл хуваарилалт хийх эсэхийг тодорхойлсон үед хуваарилалт хийх зорилгоор эзэмшиж буй хөрөнгийн бүртгэлийг зогсоон 28-29-р догол мөрийн бүртгэлийн горимыг ашиглана.

СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга

Энэхүү өөрчлөлт нь СТОУС 7-ын 42Е-42Н хэсэгт заасан тодруулгын шаардлагыг хэрэглэх зорилгоор “үргэлжилсэн сайжралт”-д үйлчилгээний гэрээг хамруулах нөхцлийг тодорхойлоход Банкуудад туслах нэмэлт удирдамжуудыг өгсөн. Жишээ нь, үйлчилгээний төлбөр нь тоо хэмжээнээс эсвэл шилжүүлсэн санхүүгийн хөрөнгөнөөс цуглуулан авсан мөнгөн урсгалын цаг хугацаанаас хамаардаг эсвэл тогтмол төлбөртэй гэрээний хувьд гүйцэтгэлийн шаардлага хангаагүйгээс төлбөрийн хэмжээ буурах гэх зэрэг нөхцөл байдал үүсдэг.

СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга

СТОУС 7 Тодруулга – Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн хаалт –д орсон нэмэлт өөрчлөлт нь завсрын үе болгонд шаардагдахгүй гэдгийг тайлбарлаж өгсөн. Гэхдээ НББОУС 34-ийн ерөнхий зарчмын шаардлагыг хангахын тулд НББОУС 34 Завсрын үеийн санхүүгийн тайлагнал–д нийцүүлэн санхүүгийн завсрын хураангуй тайлангаа бэлтгэсэн бол нэмэлт тодруулга хийхийг шаардана.

Банкны хувьд хүчин төгөлдөр болоогүй буюу хэрэглэж эхлээгүй стандартууд, стандартын нэмэлт өөрчлөлт болон тайлбарууд

Энэхүү санхүүгийн тайлангуудыг баталгаажуулах үед Нягтлан болох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (НББОУСЗ)-өөс шинээр батлан хэвлэсэн стандартууд, одоо байгаа стандартуудад оруулсан зарим нэмэлт, өөрчлөлтүүд нь тухайн Банкны хувьд хүчин төгөлдөр болоогүй буюу хэрэглэж эхлээгүй байж болно.

Банкны Удирдлага нь дээрх бүх мэдэгдлүүдийг тухайн мэдэгдлийн хүчин төгөлдөр болох хугацааны дараа тайлангийн эхний үед Банкны Нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгах хүлээлттэй байна. Банкны санхүүгийн тайланд хамааралтай шинээр батлан гаргасан стандартууд, одоо байгаа стандартуудад оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийн талаарх мэдээллийг доор харуулав. Зарим шинэ стандартууд болон тайлбарууд нь Банкны санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй гэсэн хүлээлт байна.

НББОУС 12 *Орлогын албан татвар* –т орсон нэмэлт, өөрчлөлт

НББОУСЗ-өөс НББОУС 12 *Орлогын албан татвар*–т *Бодит бус алдагдлын хувьд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрөх* гэсэн багахан өөрчлөлт оруулсан. Эдгээр өөрчлөлт нь бодит үнэ цэнээр үнэлэгдсэн өрийн хэрэгслийн хувьд, ялангуяа зах зээлийн хүү буурснаар өрийн хэрэгслийн бодит үнэ цэнэ түүний өртгөөс багасах үед хойшлогдсон татварын хөрөнгийг бүртгэх талаар тайлбарласан.

Энэхүү өөрчлөлт нь дараах зүйлийг тодорхой болгосон. Үүнд:

- Өрийн хэрэгслийн бодит бус алдагдлыг бодит үнэ цэнээр болон татварын зорилгоор өртгөөр хэмжсэнээр тухайн өрийн хэрэгслийг эзэмшиж байгаа этгээд өрийн хэрэгслээ худалдах эсвэл хэрэглэснээр дансны үнээ нөхөх хүлээлттэй эсэхээс үл хамааран татвар тооцох орлогоос хасагдах түр зөрүүг нэмэгдүүлнэ;
- Хөрөнгийн дансны үнэ нь ирээдүйд татвар ногдуулах орлогын хэмжээг хязгаарлахгүй;
- Ирээдүйд татвар ногдуулах орлогын тооцоо нь татвар ногдуулах орлогоос хасагдах түр зөрүүг буцааснаар үүсэх татварын хасагдуулгыг оруулж тооцдоггүй.
- Татварын хуулиар татвар ногдуулах орлогын эх үүсвэрт ямар нэгэн хязгаар тавьсан эсэх буюу татвар ногдуулах орлогоос хасагдах түр зөрүүг буцааснаар хасагдуулах боломжтой эсэхийг байгууллага нягталж үзнэ. Хэрэв татварын хуулиар ямар нэгэн хязгаарлалт хийгээгүй бол байгууллага нь татвар ногдох орлогоос хасагдах тухайн түр зөрүүг түр зөрүүний зүйл бүртэй хоршуулан тооцож үзнэ. Энэхүү өөрчлөлт нь 2017 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэх жилийн тайлант үед хүчин төгөлдөр болсон бөгөөд өөрчлөлтийг хэрэгжүүлсэн байгууллагууд энд заасан тайлант үеийн санхүүгийн тайланд хэрэгжүүлэн ажилласан байна. үзүүлэхгүй гэж үзэж байна.

СТОУС 9 *Санхүүгийн хэрэглүүр* (2014)

НББОУСЗ-өөс НББОУС 39 *Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөх болон хэмжих* –ийг орлуулах үйл ажиллагаагаа дуусгавар болгон СТОУС 9 *Санхүүгийн хэрэглүүр* (2014)-ийг баталсан. Шинэ стандарт нь НББОУС 39-т санхүүгийн хөрөнгийн задаргаа болон

хэмжилтийн талаарх удирдамжинд ихээхэн өөрчлөлт оруулж, санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тооцох “хүлээгдэж буй зээлийн алдагдал” загварыг шинээр нэвтрүүлсэн. СТОУС 9-өөр Хейджийн бүртгэлийг хэрэглэх талаар шинэ удирдамжийг мөн өгсөн.

Энэхүү шинэ стандартаас Банкны санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг Банкны удирдлага хараахан тооцоогүй байна. Шинэ стандарт 2018 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэх жилийн санхүүгийн тайлант үед хүчин төгөлдөр хэрэгжинэ.

СТОУС 15 “Харилцагчтай байгуулсан гэрээний орлого”

СТОУС 15 нь хүлээн зөвшөөрөх орлогын хэмжээ болон хугацааг тодорхойлсон иж бүрэн тогтолцоог бий болгосон. Энэхүү стандарт нь НББОУС 18 “Орлого”, НББОУС 11 “Барилгын гэрээ” болон тэдгээртэй холбоотой тайлбаруудыг орлох болно. Энэхүү шинэ стандарт нь хяналтад суурилсан орлого хүлээн зөвшөөрөх загварыг бий болгож одоогийн СТОУС-д дэлгэрэнгүй тайлбарлаагүй нэмэлт зааварчилгааг оруулж өгсөн. Жишээ нь: үүрэг хариуцлагын гүйцэтгэл, үнэ, үйлчлүүлэгчийн эргэн төлөлтийн эрх, нийлүүлэгчийн дахин худалдан авалтын сонголт, бусад нарийн төвөгтэй байдал зэрэгт хэрхэн зохицуулалт хийх.

СТОУС 15 нь 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэнэ. Банкны удирдлага СТОУС 15-н нөлөөллийн талаар үнэлгээ хийгээгүй байна.

СТОУС 16 Түрээс

СТОУС 16 нь түрээсийн бүртгэлд тавигдах шинэ шаардлага болон өөрчлөлтүүдийг илэрхийлнэ. СТОУС 16-аар түрээслэгчээс хөрөнгийг “ашиглах эрх” болон түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрч түрээсийг “балансын зүйл” болгохыг шаарддаг.

СТОУС 16:

- Түрээсийн нэр томъёог өөрчилсөн;
- Түрээсийн бус зүйл, түрээсийн хувьсах төлбөр болон сонголтын хугацаа зэрэг цогц асуудлыг хөрөнгө болон өр төлбөрт бүртгэх шаардлагыг тодорхойлсон;
- Богино хугацааны түрээс болон бага үнэтэй хөрөнгийн түрээсийг чөлөөлсөн;
- Зарж эргэн түрээслэх хэлцлийн бүртгэлийг өөрчилсөн;
- НББОУС 17-ын түрээслүүлэгчийн бүртгэлд баримталсан хандлагын ихэнхийг хадгалсан;
- Тодруулга хийх шинэ шаардлагыг нэвтрүүлсэн.

СТОУС 16 нь 2019 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэх тайлант үеэс хүчин төгөлдөр болно. Хэрэв СТОУС 15 *Хэрэглэгчтэй байгуулсан гэрээнээс олсон орлого*-ыг хэрэглэх бол энэхүү стандартыг эрт хэрэглэхийг зөвшөөрсөн. Банкны удирдлага нь СТОУС 16-аас Банкны санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг хараахан тооцоогүй байна.

2.6 Санхүүгийн тайлангийн дахин тайлагнал

Өмнөх оны харьцуулсан мэдээллийг багтаасан санхүүгийн тайлангийн алдаа засах шаардлага бий болсон тайлант онд залруулга хийгдсэн байдлаар толилуулна. Тийм учраас толилуулсан тайлант хугацаа тус бүрт хамааралтай залруулгын дүн тухайн тайлант оны санхүүгийн тайланд багтана.

3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй

3.1 Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт

Санхүүгийн байгууллага болон бусад аж ахуйн нэгжийн хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт нь охин, хараат компани, хамтын хяналттай компанийн аль нь болох эсэхийг банк холбогдох хууль тогтоомж болон СТОУС-ын дагуу үнэлнэ. Хэрэв хяналт тогтоосон эсвэл мэдэгдэхүйц нөлөө буюу хамтын хяналт үүссэн болохыг нотлох нотолгоо байхгүй бөгөөд хувьцааг арилжааны зорилгоор эзэмшээгүй тохиолдолд уг хөрөнгө оруулалтыг борлуулахад бэлэн өмчийн үнэт цаасаар ангилж, бүртгэнэ.

Банк хараат компани ба хамтын хяналттай компанид оруулсан хөрөнгө оруулалтыг өмчийн аргаар бүртгэнэ. Хэрэв банк НББОУС 27-ийн дагуу тусдаа санхүүгийн тайлан бэлтгэдэг бол хараат компани ба хамтын хяналттай компанид оруулсан хөрөнгө оруулалтыг тусдаа санхүүгийн тайланд өртгөөр бүртгэж, тайлагнана.

Банк нь 100 хувь эзэмшдэг 2 компанитай байсан бөгөөд тайлант хугацаанд 1 компани нь эзэмшилээс хасагдсан байна. СТОУС 10-ын (4а) нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгээгүй. Энэхүү аудитын тайланг НББОУС 27 Тусдаа Санхүүгийн тайлан-гийн дагуу бэлтгэсэн.

Санхүүгийн тайланг бэлтгэхэд ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн голлох бодлогуудыг доор толилуулав.

3.2 Гадаад валют

Гадаад валютаарх ажил гүйлгээ

Санхүүгийн тайланг бэлтгэхэд үйл ажиллагааны валютаас бусад валютаарх ажил гүйлгээг ажил гүйлгээ гарсан өдөр Монгол банкнаас зарласан ханшаар бүртгэнэ. Тайлант хугацаа бүрийн эцэст гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийг Монгол банкнаас тайлагналын өдрөөр зарласан ханшийг ашиглан дахин хөрвүүлэх бөгөөд 2017 оны 12 дугаар сарын 31-нд төгрөгийн 1 ам.доллартай харьцах ханш 2,427.13 төгрөг, 1 евротой харьцах ханш 2,897.87 төгрөгтэй байв. (2016 оны 12 дугаар сарын 31-нд: 1 ам.доллар 2,489.53 төгрөг, 1 евротой харьцах ханш 2,605.79) Мөнгөн бус зүйлсийг дахин хөрвүүлэхгүй бөгөөд бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар дахин хөрвүүлсэн гадаад валютаар илэрхийлэгдсэн бодит үнэ цэнээр бүртгэсэн мөнгөн бус зүйлсээс бусад мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ гарсан өдрийн валютын ханшийг ашиглан хөрвүүлсэн түүхэн өртгөөр хэмжинэ.

Мөнгөн зүйлсийг дахин хөрвүүлэх болон төлбөр тооцоо хийхэд үүссэн ханшийн зөрүүг тухайн хугацааны ашиг, алдагдалд багтаана. Мөнгөн бус зүйлсийн хөрвүүлгээс үүссэн зөрүүний олз, гарзыг шууд өмчид хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийн дахин хөрвүүлгээс үүссэн ханшийн зөрүүг тайлант хугацааны ашиг, алдагдалд багтаана.

3.3 Үндсэн хөрөнгө

Ажил үйлчилгээний зорилгоор ашиглаж буй барилга байгууламж, тавилга эд хогшил, компьютер тоног төхөөрөмж, оффисийн тоног төхөөрөмж зэрэг хөрөнгүүдийг санхүүгийн

тайланд дахин үнэлсэн дүн буюу дахин үнэлгээ хийсэн өдрөөрх дүнгээс дараа үеийн хуримтлагдсан элэгдсэн болон дараа үеийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр тайлагнана.

Дахин үнэлгээний өдрөөрх хуримтлагдсан элэгдлийг хөрөнгийн дансны нийт үнээс хасах ба гарсан цэвэр дүнг хөрөнгийн дахин үнэлсэн дүн гарах хүртэл тооцно. Дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү гаргахгүй байх үүднээс тайлагналын үеийн эцэс бүрт дахин үнэлгээ хийлгэнэ.

Хөрөнгийн дахин үнэлгээнээс бий болсон аливаа өсөлтийг (энэ өсөлт нь өмнөх үед ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн ижилхэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралтыг буцааж, өсөлтийг өмнө нь хассан бууралтын ашиг, алдагдал руу кредитлэж байгаагаас гадна) бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт хүлээн зөвшөөрч, эздийн өмчийн хэсэгт дахин үнэлгээний нөөцөөр толилуулна. Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ буурсан бол бууралтыг ашиг алдагдлаар бүртгэнэ. Харин хөрөнгийн дахин үнэлгээнээс бий болсон дансны үнийн бууралтыг тухайн хөрөнгийн өмнөх дахин үнэлгээтэй холбоотой хөрөнгийн дахин үнэлгээний нөөцийн үлдэгдлээс давж байвал ашиг, алдагдлыг бууруулна.

Үндсэн хөрөнгийн данснаас хассан, ашиглалтаас гаргаснаас үүссэн олз, гарзыг тухайн хөрөнгийн борлуулалт болон дансны үнийн зөрүүгээр тодорхойох ба олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Элэгдлийг хөрөнгө тус бүрийн ашиглах хугацаагаар шулуун шугамын аргаар тооцож, ашиг алдагдлаар тусгана. Хөрөнгийг ашиглах боломжтой болсон үед элэгдүүлж эхлэнэ. Хөрөнгийн ашиглах хугацааг дараах байдлаар тогтооно.

Байшин барилга	- 40 жил
Автомашин	- 10 жил
Тавилга, эд хогшил	- 10 жил
Компьютер, дагалдах хэрэгсэл	- 3 жил

3.4 Биет бус хөрөнгө

Банк худалдан авсан хязгаарлагдмал ашиглах хугацаатай биет бус хөрөнгийн өртгөөс хуримтлагдсан хорогдол болон үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр тайлагнана.

Хорогдлыг биет бус хөрөнгийн ашиглах хугацаагаар шулуун шугамын аргаар тооцож, ашиг алдагдлаар тусгах ба програм хангамжийн хувьд 2 ба 10 жил, лицензийн хувьд ашиглах хугацаа 5 жил байна.

3.5 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

Түрээсийн орлого олох болон капиталын үнийг өсгөх зорилгоор эзэмшиж буй хөрөнгө буюу хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг тээврийн зардлыг багтаасан өртгөөр анх хүлээн зөвшөөрнө. Анх хүлээн зөвшөөрсний дараа бодит үнэ цэнээр хэмждэг.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарзыг тухайн үүссэн үеийн ашиг алдагдалд хамруулна.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөөс олсон түрээсийн орлого болон үйл ажиллагааны зардлыг орлого, бусад зардлаар тус тус бүртгэнэ.

3.6 Бараа материал

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар тайлагнана. Цэвэр боломжит үнэ цэнийг бизнесийн хэвийн ажиллагааны үеийн бараа материалын борлуулах үнээс бараа материалыг иж бүрдэл болгох зардал ба борлуулах зардлыг хасч тооцно. Бараа материалын өртөг жинлэсэн дунджийн зарчимд суурилдаг ба бараа материалын худалдан авалтын зардал болон одоогийн байршил, нөхцөлд авчрахтай холбоотой гарсан бүх зардал багтана.

3.7 Санхүүгийн хэрэглүүр

Хүлээн зөвшөөрөлт, анхдагч хэмжилт ба үл хүлээн зөвшөөрөлт

Банк тухайн санхүүгийн хэрэглүүрийн гэрээний заалтуудын нэг хэсэг болсон үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгөөс бий болох мөнгөний урсгал дахь гэрээний эрх дуусгавар болоход эсвэл санхүүгийн хөрөнгө ба бүх бодит эрсдэл, шагнал шилжихэд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн өр төлбөрийг барагдуулсан, чөлөөлсөн, хүчингүй болгосон эсвэл хугацаа дууссан үед нь үл хүлээн зөвшөөрнө.

Бодит үнэ цэнээр анхлан хэмжсэн бөгөөд ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр илэрхийлснээс бусад санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг анх бодит үнэ цэнэ дээр ажил гүйлгээний өртөгийг нэмсэн дүнгээр хэмжинэ.

Санхүүгийн хөрөнгийн ангилал ба дараа үеийн хэмжилт

Дараа үеийн хэмжилтийн зорилгоор хейджийн хэрэглүүрээс бусад санхүүгийн хөрөнгө анхдагч хүлээн зөвшөөрөлтөөр дараах категорит хуваагдана.

- Зээл ба авлага
- Ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө
- Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө
- Гэрээний хугацаа дуустал эзэмших санхүүгийн хөрөнгө

Санхүүгийн хөрөнгүүд хэрэглүүрийн шинж чанар, зорилгоос шалтгаалан анхдагч хүлээн зөвшөөрөлтөөр өөр өөр категорит ордог. Санхүүгийн хэрэглүүрийн категори нь түүний хэмжилт, санхүүгийн хэрэглүүрийн үр дүнд бий болсон орлого, зарлагыг ашиг, алдагдлаар эсвэл шууд бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөх эсэхэд чухал хамааралтай. Банкны категорилсон санхүүгийн хөрөнгийн хураангуйг тодруулга 27-с харна уу.

Банк ерөнхийдөө бүх санхүүгийн хөрөнгөө төлбөр тооцоо хийх өдрийн бүртгэлээр хүлээн зөвшөөрдөг. Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэх талаарх үнэлгээг тайлант хугацааны эцэс бүрт хийнэ. Бусад зардалд толилуулсан худалдааны авлагын үнэ цэнийн бууралтаас бусад ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгөтэй холбоотой бүх орлого, зардлыг санхүүгийн зардал, санхүүгийн орлого эсвэл бусад санхүүгийн зүйлсэд толилуулна.

i. Зээл ба авлага

Зээл болон авлага нь идэвхтэй зах зээл дээр арилжаалагддаггүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй дериватив бус санхүүгийн хөрөнгө юм. Зээл, авлагад худалдааны ба бусад авлага, гар дээрх бэлэн мөнгө болон банкин дах мөнгө багтана.

Худалдааны ба бусад авлага

Эргэлтийн дансны авлагыг бодит үнэ цэнээр анхлан хүлээн зөвшөөрнө. Харин дараа үед хорогдсон өртөгөөс үнэ цэнийн бууралтын нөөцийг хассан дүнгээр хэмжинэ. Худалдааны авлагын үнэ цэнийн бууралтын нөөцийг Банк уг авлагыг анхдагч нөхцлийн дагуу бүгдийг цуглуулах боломжгүй болсон гэсэн бодит нотолгоотой болсон үед байгуулна. Зээлдэгчид учирсан санхүүгийн томоохон бэрхшээл, гэрээ үл биелүүлэх болон төлөлт удаашрах зэрэг нь уг худалдааны авлагын үнэ цэнэ буурсныг илтгэнэ. Нөөцийн дүн нь хөрөнгийн дансны үнэ болон анхдагч үр ашигт хүүний түвшингээр дискаунтчилсан ирээдүйд орохоор тооцоолсон мөнгөн гүйлгээ хоорондын зөрүү юм.

Авлагын хасагдуулгын үлдэгдлийг тайлант хугацааны ашиг алдагдалд тусгасан төлбөр эсвэл орлогыг бүртгэж тохируулна. Харилцагчийн дансны үлдэгдэлтэй холбоотой данснаас хассан аливаа дүнг өмнө нь байсан найдваргүй авлагын хасагдуулгаас хасна. Цуглуулах боломжгүй гэж үзсэн бүх дансны авлагыг данснаас хасна.

Бэлэн мөнгө ба банкин дахь үлдэгдэл

Банкны бэлэн мөнгө ба банкин дахь үлдэгдэл нь гар дээрх бэлэн мөнгө, банкин дах дансад болон замд яваа бэлэн мөнгөөс бүрдэнэ.

ii. Ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр бүртгэсэн санхүүгийн хөрөнгө

Бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хөрөнгийг худалдах зорилгоор эзэмшиж буй эсвэл анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараа бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг ашиг алдагдлаар тусгадаг гэж ангилна. Уг тодорхойлолтын дагуу хейджийн бүртгэлийн шаардлагыг хангахгүй бүх дериватив санхүүгийн хэрэглүүр энэ категорит багтана.

Дериватив санхүүгийн хэрэглүүрээс үүсч буй аливаа олз, гарз нь бодит үнэ цэнийн өөрчлөлтөд суурилдаг. Уг бодит үнэ цэнийн өөрчлөлтийг идэвхитэй зах зээлийн ажил гүйлгээг, идэвхитэй зах зээл байхгүй бол үнэлгээний аргачлалт ашиглан тодорхойлно.

iii. Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө

Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмжих ба дараа үе дэх өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрнө. Борлуулах боломжтой гэж ангилсан санхүүгийн хөрөнгөөс үүссэн олз, гарзыг зөвхөн борлуулагдсан эсвэл тухайн хөрөнгө оруулалтын үнэ цэнэ буурсан үед ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнэ буурсан тохиолдолд өмнө нь бусад орлогод хүлээн зөвшөөрсөн аливаа алдагдлыг ашиг алдагдалд шилжүүлнэ. Орлогын тайлангийн өмчийн хэрэглүүрт хүлээн зөвшөөрсөн алдагдлыг орлогын тайлангаар дамжуулж буцаахгүй харин өмчийг тохируулна. Дараах үеийн өсөлт нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын дараа үүсэх үйл явдалд бодитоор холбогдох боломжтой бол өрийн үнэт цаасны үнэ цэнийн бууралтын дүнд бий болсон өмнөх тайлант хугацааны орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн гарзыг

бий болсон өмнөх тайлант хугацааны орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн гарзыг орлогын тайлангаар дамжуулж буцаана.

iv. Гэрээний хугацаа дуустал эзэмших санхүүгийн хөрөнгө

Гэрээний хугацаа дуустал эзэмших санхүүгийн хөрөнгө нь тогтоосон эсвэл тодорхойлж болох төлбөртэй, тогтоосон дуусах хугацаатай дериватив бус санхүүгийн хөрөнгө бөгөөд арилжааны банкууд дах хадгаламж үүнд орно. Банкны удирдлага хөрөнгө оруулалтыг хугацаа нь дуустал эзэмших зорилготой бол түүнийг хугацаа дуустал эзэмших хөрөнгө оруулалтаар ангилна.

Хадгаламжийг дараах үед хэмжинэ үр ашигт хүүний арга ашиглан хорогдсон дүнгээр хэмжинэ. Мөн хадгаламжийн үнэ цэнэ буурсан гэсэн бодитой нотолгоо байвал санхүүгийн хөрөнгийг урьдчилан тооцоолсон мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр хэмжинэ. Хадгаламжийн дансны дүнд гарсан аливаа өөрчлөлтийг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн өр төлбөрийн ангилал ба дараа үеийн хэмжилт

Банкны санхүүгийн өр төлбөрт зээл ба зээллэг, санхүүгийн түрээсийн өр төлбөрийг багтаасан худалдааны ба бусад өглөг орно. Банкны санхүүгийн өр төлбөрийн категорилсон хураангуйг тодруулга 25-27-д харуулав.

i. Зээл ба зээллэг

Зээл ба зээллэгийг зээллэгтэй холбоотой гаргалтын зардлын цэвэр дүн буюу бодит үнэ цэнээр анхлан хүлээн зөвшөөрнө. Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараагаар зээл ба зээллэг нь өртөг болон үр ашигт хүүгийн сууриарх зээллэгийн хугацааны турш ашиг алдагдалд хүлээн зөвшөөрсөн төлөх үеийн үнийн зөрүүний хамт хорогдлын өртөгөөр илэрхийлэгдэнэ. Хөрөнгийн нэг хэсэг болгон капиталжуулсан бэлтгэл шаардлагатай хөрөнгийн худалдан авалт, барилга эсвэл үйлдвэрлэлд шууд холбоотой зээлийн өртөгөөс бусад зээллэгтэй холбоотой үүссэн хүү болон бусад зардлыг санхүүгийн зардлын хэсгээр хүлээн зөвшөөрнө.

ii. Худалдааны ба бусад өглөг

Худалдааны ба бусад өглөгийг бодит үнэ цэнээр, дараа үед хорогдуулсан өртгөөр илэрхийлнэ.

3.8 Үнэ цэнийн бууралт

Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Ашиглах хугацаа нь тодорхойгүй хөрөнгийг хорогдуулахгүй бөгөөд жил бүр үнэ цэнийн бууралтын тест хийнэ. Харин хорогдуулах хөрөнгийн дансны үнэ нөхөгдөхөөргүй болсныг илтгэх өөрчлөлт, нөхцөл байдал үүссэн үед үнэ цэнийн бууралт хийх эсэхийг авч үзнэ. Үнэ цэнийн бууралтын алдагдлыг хөрөнгийн нөхөгдөх дүнгээс давсан дансны үнийн дүнгээр хүлээн зөвшөөрнө.

Борлуулах үнэ болон ашиглалтын үнэ цэнийн аль их нь нөхөгдөх дүн байна. Хөрөнгийн нөхөгдөх үнэ цэнэ эсвэл мөнгө болгогч нэгж нь хөрөнгийн дансны үнээс бага байхаар тооцоологдсон бол хөрөнгийн дансны үнэ эсвэл мөнгө бий болгогч нэгжийг нөхөгдөх дүн рүү бууруулна. Холбогдох хөрөнгийг дахин үнэлсэн дүнгээр илэрхийлж, үнэ цэнийн

бууралтын гарзыг дахин үнэлгээний бууралтаар авч үзээгүй бол үнэ цэнийн бууралтын гарзыг даруй зардлаар хүлээн зөвшөөрнө.

Үнэ цэнийн бууралт дараа үед буцаагдах тохиолдолд хөрөнгийн дансны үнэ эсвэл мөнгө бий болгогч нэгжийг хөрөнгийн дахин тооцоолсон нөхөгдөх дүн рүү өсгөнө. Гэхдээ ингэснээр дансны өсгөсөн дүн нь өмнөх үед хөрөнгө болон мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралт хүлээн зөвшөөрөөгүй гэдгийг тодорхойлох байсан дансны үнээс хэтрэхгүй. Холбогдох хөрөнгийг дахин үнэлсэн дүнгээр илэрхийлж, үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтыг дахин үнэлгээний өсөлтөөр авч үзээгүй бол үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтыг даруй орлогоор хүлээн зөвшөөрнө

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдсэн санхүүгийн хөрөнгөөс бусад санхүүгийн хөрөнгөд үнэ цэнийн бууралтын шинж бий эсэх үнэлгээг тайлант хугацаа бүрт хийнэ. Санхүүгийн хөрөнгийн анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараах нэг ба түүнээс олон үйл явдлын үр дүнд хөрөнгө оруулалтын ирээдүйд тооцоолсон мөнгөн урсгалд нөлөөлсөн гэх бодит нотолгоо байвал санхүүгийн хөрөнгийн үнэ цэн буурна.

Хорогдуулсан өртөгөөр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын дүн нь хөрөнгийн дансны үнэ болон анхдагч үр ашигт хүүгээр дискаунтчилж тооцоолсон ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийн зөрүү байна. Санхүүгийн хөрөнгийн дансны үнийг хасагдуулгын дансыг ашиглан дансны үнийг бууруулсан худалдааны авлагаас бусад тохиолдолд бүх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзаар бууруулна.

Борлуулах боломжтой өмчийн хэрэглүүрээс бусад тохиолдолд дараа үед үнэ цэнийн бууралтын алдагдал буурч, уг бууралт нь үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараа үүссэн үйл явдалтай бодитоор холбогдож байвал өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдлаар дамжуулан буцаана. Гэхдээ ингэж буцаасны улмаас үнэ цэнийн бууралтыг буцаасан өдрөөрх хөрөнгө оруулалтын дансны үнэ нь уг үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрөөгүй байсан бол хорогдуулсан өртгийн байх дүнгээс хэтэрч болохгүй.

Борлуулах боломжтой өмчийн үнэт цаасны хувьд үнэ цэнийн бууралтын алдагдлын дараах бодит үнэ цэнийн бууралтыг шууд өмчид хүлээн зөвшөөрнө.

3.9 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө

Банкны ойрын 12 сарын дотор борлуулахаар зорьж буй эргэлтийн бус хөрөнгө ба бүлэг хөрөнгийг борлуулах зорилгоор эзэмшиж буй гэж ангилан санхүү байдлын тайланд уг ангиллаар толилуулна.

Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийг уг ангилалд оруулахын яг өмнөх дансны үнэ болон бодит үнэ цэнээс борлуулалтын өртөгийг хассан дүнгийн аль багаар хэмжинэ. Ийм хөрөнгийг элэгдүүлж, хорогдуулахгүй. Харин санхүүгийн хөрөнгө, хойшлогдсон татварын хөрөнгө зэрэг борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийг ердийнхөөр хэмжинэ.

Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийн борлуулалт болон дахин үнэлгээнээс гарах аливаа ашиг, алдагдлыг орлогын тайланд “бусад орлого”, “бусад зардал”-д тус тус багтаана. Хөрөнгийг данснаас хассаны үр дүнд өмчид үлдэх дахин үнэлгээний нэмэгдлийг хуримтлагдсан ашиг руу шилжүүлнэ.

3.10 Өмч

Банкны гаргасан өмчийн хэрэглүүрийг хүлээж авсан орлогоор бүртгэнэ. Хувьцаат капитал нь гаргасан хувьцааны нэрлэсэн үнийг илэрхийлнэ. Хуримтлагдсан алдагдалд тайлант болон өмнөх хугацааны бүх ашиг, алдагдал багтана. Ногдол ашгийг зарласан хугацаанд нь өр төлбөрөөр хүлээн зөвшөөрнө.

3.11 Нөөц

Нөөцийг Банкинд өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн эсвэл үүсмэл хариуцлага бий болж, уг үүрэг хариуцлагыг барагдуулахад эдийн засгийн өгөөжийн гадагш урсгал шаардагдах магадлалтай болсон үед санхүү байдлын тайланд хүлээн зөвшөөрнө. Хэрэв үүний нөлөөлөл материаллаг бол нөөцийг ирээдүйд тооцоолсон мөнгөний урсгалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн одоогийн зах зээлийн үнэлгээ болон тухайн өр төлбөрийн эрсдэлд нөлөөлөх татварын өмнөх хувь хэмжээгээр дискаунтчлах замаар тодорхойлно.

3.12 Орлогын албан татвар

Тайлант үеийн татвар гэдэг нь тайлант оны эцсээр хүчинтэй болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татварын хувь хэмжээг ашиглан тухайн оны татвар ногдох орлогод төлөх татварын өглөг болон өмнөх онуудтай холбоотой татварын өглөгийн залруулга юм.

Хойшлогдсон татварыг санхүүгийн тайлан дах хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татвар ногдох ашгийн тооцоололд ашиглан холбогдох татварын суурь хоорондын түр зөрүүгээр хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын өр төлбөрийг ерөнхийдөө бүх татвар ногдох түр зөрүүнд хүлээн зөвшөөрдөг. Хойшлогдсон татварын хөрөнгийг ерөнхийдөө түр хасагдах зөрүүг ашиглаж болохуйц хэмжээний татвар ногдох ашиг олох магадлалтай байгаа үед бүх хасагдах түр зөрүүнд хүлээн зөвшөөрнө. Ийм хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг гүүдвилийн анхдагч хүлээн зөвшөөрөлт эсвэл ажил гүйлгээн дэх бусад хөрөнгө, өр төлбөрийн анхдагч хүлээн зөвшөөрөлт нь татвар ногдох орлого ба нягтлан бодох бүртгэлийн ашгийн аль алинд нөлөөлөхгүй байвал хүлээн зөвшөөрөхгүй.

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацаа бүрийн эцэст эргэж харах ба хангалттай хэмжээний татвар ногдох орлогоор тухайн хөрөнгө бүхлээрээ эсвэл тодорхой хэсэг нь нөхөгдөх боломжтой болох үед бууруулна.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эсвэл тайлант оны эцсээр хүчин төгөлдөр болсон татварын хувь хэмжээ (болон татварын хууль)-нд үндэслэн тухайн өр төлбөрийг барагдуулах эсвэл хөрөнгийг хүлээн зөвшөөрөх тайлант онд мөрдөгдөхөөр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хэмжигдэнэ. Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн хэмжилт нь тайлант хугацааны эцэст Банк хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнийг нөхөх буюу барагдуулахаар хүлээж байгаагаас үүсэх татварын үр дагаварт нөлөөлдөг.

3.13 Орлогын хүлээн зөвшөөрөлт

Орлого нь тайлант хугацаанд хөрөнгийн дотогшлох урсгал болон хөрөнгийн сайжруулалт, эсвэл хувь нийлүүлэгчдээс оруулсан хөрөнгөтэй холбоогүйгээр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, өр төлбөрийг бууруулах хэлбэрээр гарах эдийн засгийн үр өгөөжийн өсөлт юм. Орлогод орлого болон олз багтана. Орлого нь банкны үйл ажиллагааны явцад үүсдэг бөгөөд төлбөр, хураамж, хүү болон ногдол ашиг зэргийг хамруулна. Банкны үндсэн орлого нь хүүгийн орлого ба хураамж, шимтгэлийн орлого юм.

Хүүгийн орлого нь тодорхой гэрээний үндсэн дээр зээлдэгчдэд олгосон зээл, бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгийг ашиглуулсны төлөө авч буй төлбөр юм.

Орлогыг хүлээн авсан мөнгө эсвэл үүссэн авлагын бодит үнэ цэнээр үнэлнэ.

4 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн гүйлгээний тайлан бэлтгэх зорилгоор Мөнгөтэй адилтгах хөрөнгөд үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай богино хугацааны хөрөнгө оруулалт зэргийг хамруулдаг. Мөнгөтэй адилтгах хөрөнгийг хөрөнгө оруулалт болон бусад зорилгоос илүү богино хугацаат өр төлбөрийг барагдуулах зорилгоор эзэмшдэг. Хэрэв мөнгөтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг бол Банк нь хөрөнгө оруулалтыг мөнгөтэй адилтгах хөрөнгөөр ангилна.

<i>Мянган төгрөгөөр</i>	2017 оны 12 сарын 31-ний Үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний Үлдэгдэл
<i>Мөнгө</i>		
Бэлэн мөнгө	7,053,835	2,957,299
Монголбанкинд байршуулсан мөнгө (3 хүртэлх сарын хугацаатай)	2,667,726	29,823,197
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө (*1)	1,690,633	644,264
Мөнгөтэй адилтгах хөрөнгө (*2)	74,907,181	12,485,655
Мөнгөн хөрөнгөд хуримтлуулж тооцсон хүү	-	-
	<u>86,319,376</u>	<u>45,910,415</u>

(*1) Бусад банкинд байршуулсан хөрөнгийн 2017 оны 12 дугаар сарын 31 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл нь дараах байдалтай байна. Үүнд:

<i>Мянган төгрөгөөр</i>	2017 оны 12 сарын 31-ний Үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний Үлдэгдэл
Дотоодын банк дахь харилцах	193,715	297,460
Гадаадын банк дахь харилцах	1,489,457	346,804
СБайгууллага ҮЦТТХТ	7,461	-
	<u>1,690,633</u>	<u>644,264</u>

*2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 3 хүртэлх сарын хугацаатай Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн шалгуурыг хангах дотоодын банкинд байршуулсан хадгаламжийн үлдэгдэл дараах байдалтай байна.

<i>(*2) Мөнгөтэй адилтгах хөрөнгө</i>	2017 оны 12 сарын 31-ний Үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний Үлдэгдэл
Монголбанкны үнэт цаас (3 хүртэлх сарын хугацаатай)	75,000,000	12,500,000
Үнэт цаасны хорогдуулаагүй хямдруулалт	(92,819)	(14,345)
	<u>74,907,181</u>	<u>12,485,655</u>

5 Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө

5.1 Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Монголбанкинд байршуулсан хөрөнгө (*1)	30,543,282	13,330,477
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө (*2)	6,000,000	2,150,392
- Дотоодын банк	-	-
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	55,233	980
	<u>36,598,515</u>	<u>15,481,849</u>

5.2. Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Мянган төгрөгөөр	Хугацаа хэтрээгүй
Монголбанкинд байршуулсан хөрөнгө	30,543,282
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	6,000,000
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	-
Хасах нь: Эрсдэлийн сан	(55,233)
Дүн	<u>36,598,515</u>

(*1) Банк нь Монголбанкны 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А-1а/1345 тоот шаардлагын дагуу Монголбанк дахь төгрөгийн харилцах дансны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх үлдэгдлийн доод хэмжээг 22,695,837.44 мянган төгрөг, гадаад валютын харилцах дансны үлдэгдлийн доод хэмжээг 8,889,095.50 мянган төгрөгөөр (2016.12.31: 11,688,909 мянган төгрөг)-өөр тус тус тогтоосон байна.

(*2) Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөнд дараах дотоодын банкуудад байршуулсан хадгаламж байна. Үүнд:

Гэрээний дугаар	Хадгалагч банк	Валют	Үлдэгдэл /валют/	Үлдэгдэл /мянган төгрөг/	Хүү /жилээр/	Нээгдсэн огноо	Хаагдах Огноо
1145101825	Голомт банк	төгрөг	6,000,000	6,000,000	12.0%	2017/11/21	2019/03/16

2017 оны 11 дүгээр сарын 21-ны өдөр Чингис хаан банк, Голомт банк хооронд 1145101825 дугаар тоот мөнгөн хадгаламжийн гэрээг байгуулсан. Гэрээний дагуу Чингис хаан банк нь 6,000,000 мянган төгрөгийг 2019 оны 3 дугаар сарын 16-н хүртэл жилийн 12%-ийн хүүтэй хадгалуулж, үндсэн төлбөр, хүүг хадгаламжийн хугацаа дуусах өдөр буцаан төлнө.

6 Хөрөнгө оруулалт

6.1. Үнэт цаасаар оруулсан хөрөнгө оруулалт

Мянган төгрөгөөр	Зээл ба авлага гэж ангилсан үнэт цаас				Нийт дүн
	Арилжааны үнэт цаас	Борлуулахад бэлэн үнэт цаас	Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	Хураамтлуулж тооцсон хүүгийн авлага	
Засгийн газрын үнэт цаас (*1)	-	-	-	-	-
Хувьцаа (*2)	666,251	-	39,119,037	-	39,785,288
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (*1)	-	855,700	-	12,333	868,033
	<u>666,251</u>	<u>855,700</u>	<u>39,119,037</u>	<u>12,333</u>	<u>40,653,321</u>

6.2. Хөрөнгө оруулалтын хугацаа

Мянган төгрөгөөр	Хугацаа		Нийт дүн
	Заагаагүй	5-аас дээш жилийн хугацаатай	
Арилжааны үнэт цаас*	666,251	-	666,251
Борлуулахад бэлэн үнэт цаас	39,119,037	-	39,119,037
Зээл ба авлага гэж ангилсан бусад үнэт цаас**	-	855,700	855,700
Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт (*3)	-	-	-
Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	12,333	-	12,333
	<u>39,797,621</u>	<u>855,700</u>	<u>40,653,321</u>

(*1) Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас

	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
	Засгийн газрын үнэт цаас	-
Засгийн үнэт цаасны хямдруулалт	-	(126,120)
	<u>-</u>	<u>9,673,880</u>

(*2) Арилжааны үнэт цаасны 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл нь дараах компаниудын хувьцаанаас бүрдэж байна. Үүнд:

	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл		2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
МИК Холдинг ХК	61,639	320,651	61,639	320,651
Хувьцааны урамшуулал	-	323,460	-	431,345
БҮК ХК	49,200	246	49,2	246
Хувьцааны урамшуулал	-	21,894	-	22,140
	<u>110,839</u>	<u>666,251</u>	<u>110,839</u>	<u>774,382</u>

(*3) Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт нь 2017 оны 12 дугаар сарын 31 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дараах байдалтай байна. Үүнд:

	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл		2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
СТАНДАРТ ПАРТНЕРС ХХК*	13,473,535	13,473,535	26,365,000	24,720,498
Русмяспром ХХК	-	784,328	10,000	8,930,872

Си Жи Эф ББСБ	16,300	16,300	16,300	16,300
Монгол 999 Үндэсний нэгдэл	-	1,000	-	1,000
МВА проперти менежмент ХХК	11,650	22,130	11,650	22,130
Эрдэнэт фүүдс ХХК /80%/	-	13,970,000	-	-
ОСМ агро трейдинг ХХК	-	10,851,744	-	-
Нийт		39,119,037		33,690,800
Үнэлгээний хасагдуулга**				(546,544)
		<u>39,119,037</u>		<u>33,144,256</u>

Банкны ТУЗ-ийн 2016 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн Б/15 тоот тогтоолоор “СТАНДАРТ ПАРТНЕРС” ХХК-ийн 100 хувийн хувьцааг нийт 10 муу зээлийн үүргийн гүйцэтгэлд тооцуулан шилжүүлэн авсан. “СТАНДАРТ ПАРТНЕРС” ХХК-ийн хувьцаа эзэмшигчтэй “Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ”-г байгуулах шийдвэрийг үндэслэн тус гэрээг байгуулж, улсын бүртгэлийн гэрчилгээнд 2016 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр өөрчлөлтийг бүртгүүлсэнээр “СТАНДАРТ ПАРТНЕРС” ХХК-ийн 100 хувь хувьцааг /нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 26,365,000 ширхэг энгийн зарласан/ шилжүүлэн авч борлуулах зориулалттай үнэт цаасны ангилалд бүртгэсэн байна. “СТАНДАРТ ПАРТНЕРС” ХХК-ийн үл хөдлөх хөрөнгө болох Khan Khills Residence хорооллын 9,298 м.кв талбайтай орон сууцыг банк шилжүүлэн авснаар хувьцаанд бүртгэн, уг орон сууцны борлуулалтаар хувьцааг хорогдуулсан байна. 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 11,246,963 мянган төгрөгийн үнэ бүхий орон сууцны борлуулалтаар хувьцааны үнийн дүнг хорогдуулж бүртгэсэн байна.

Банк нь Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Н/83 дугаар тушаалаар "Русмяспром" ХХК-ийн үнэт цаасанд 8,484,328 мянган төгрөгийн үнэлгээний хасагдуулгыг 2017 оны 4 дүгээр улиралд багтаан нэмж байгуулах шийдвэр ирсэн байна. Тайлант онд уг хөрөнгийг 8,000,000 мянган төгрөгөөр “Нүүдэлчин групп”-д хувьцааг худалдах, худалдан авах гэрээгээр 930,872 мянган төгрөгийн алдагдалтай шилжүүлж, 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар "Русмяспром" ХХК-ийн үнэт цаасанд байгуулсан эрсдэлийн санд шилжүүлэх 784,328 мянган төгрөгний үлдэгдэлтэй байна.

7 Зээл

7.1. Олгосон зээлийн үлдэгдэл, түүнд гарсан өөрчлөлт

Мянган төгрөгөөр	Бизнесийн зээл	Хэрэглээний зээл	Орон сууцны зээл	Нийт дүн
Эхний үлдэгдэл	132,944,823	1,254,823	12,340,046	146,539,693
Нэмэгдсэн	124,692,229	12,762,342	20,130,525	157,585,096
Хасагдсан (-)	(89,211,103)	(10,910,012)	(3,729,951)	(103,851,066)
Төлөгдсөн	(89,211,103)	(10,910,012)	(1,799,761)	(101,920,876)
Данснаас хассан	-	-	(1,930,190)	(1,930,190)
Бусад /ханшийн өөрчлөлт/	-	-	-	-
Эцсийн үлдэгдэл	168,425,949	3,107,153	28,740,620	200,273,723
Зээлийн хойшлогдсон төлбөр	-	-	-	-
Нэмэх нь: Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	59,317,680	48,208	271,740	59,637,628
Хасах нь: Зээлийн эрсдэлийн сан	(18,769,095)	(47,538)	(1,382,758)	(20,199,391)
	208,974,534	3,107,823	27,629,602	239,711,959

Монголбанк болон Монгол Улсын Засгийн газраас Ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох зорилгоор хэрэгжүүлж буй “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” хөтөлбөрийн хүрээнд ЧИНГИС ХААН БАНК нь өөрийн эх

үүсвэрээр болон “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу иргэдэд орон сууцны хөнгөлөлттэй зээл олгодог байна. Тайланд онд Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журмын дагуу нийт 115 зээлдэгчийн 7.5 тэрбум төгрөгийн зээлийг “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК-нд худалдсан байна. Хэрэглээний зээл нь гол төлөв тэтгэврийн болон цалингийн зээл байна.

7.2 Зээлийн барьцаа хөрөнгийн тодруулга

Мянган төгрөгөөр	Бизнесийн Зээл	Хэрэглээний зээл	Орон сууцны зээл	Нийт дүн
Баталгаагүй зээл:	378,000	-	828,430	1,206,430
Барьцаат зээл:	168,047,949	3,107,153	27,912,190	199,067,293
- Орон сууц	3,944,574	47,208	25,782,437	29,774,219
- Бусад үл хөдлөх хөрөнгө	100,920,776	224,142	948,171	102,093,089
- Арилжааны үнэт цаас	-	-	-	-
- Мөнгөн хадгаламж	-	529,365	-	529,365
- Бусад хөрөнгө	63,182,599	2,306,438	1,181,582	66,670,620
	168,425,949	3,107,153	28,740,620	200,273,723

Зээлийн барьцааны бусад хөрөнгө хэсэгт зээлдэгчийн үйлдвэрлэл үйл ажиллагаанд ашиглагдаж буй тээврийн хэрэгсэл тоног төхөөрөмж, ирээдүйн орлого зэрэг барьцаа хөрөнгийн шаардлага хангасан зүйлсийг бүртгэсэн байна. Мөн барьцаагүй зээлийн дүнг бусад хөрөнгө хэсэгт толилуулсан. Барьцаа хөрөнгөгүй зээл нь гол төлөв цалин, тэтгэврийн зээл байна. Эдгээр зээлүүдэд банк тусгайлан барьцаа хөрөнгө шаарддаггүй боловч зээлдэгчийн ирээдүйн тэтгэвэр болон цалингийн төлөлтүүдийг хянаж байдаг. Тэтгэвэр болон цалингийн зээл авах гол шаардлага нь цалин болон Засгийн Газраас авах тэтгэврийг Банкны дансаар дамжуулан авах явдал болно.

7.3 Зээлийн эрсдэлийн сангийн өөрчлөлт

Мянган төгрөгөөр	Бизнесийн зээл	Хэрэглээний зээл	Орон сууцны зээл	Нийт дүн
Эхний үлдэгдэл	18,048,280	15,573	710,034	18,773,888
Нэмж байгуулсан	9,181,553	86,859	696,898	9,965,310
Хасагдсан (-)	-	-	-	-
Зээл төлөгдсөн	(8,113,763)	(54,894)	(8,846)	(8,177,503)
Сангаас хаасан	-	-	-	-
Бусад /Ханш/	346,976	-	15,329	362,305
Эцсийн үлдэгдэл	18,769,095	47,538	1,382,758	20,199,391

Тайлант онд зээлийн эрсдэлийн сангийн өөрчлөлтөөр 9.965.310 мянган төгрөгөөр нэмэгдэж, төлөгдсөн зээлээс 8,177,503 мянган төгрөгөөр эрсдэлийн санг бууруулсан ба бусад 362,305 мянган төгрөгөөр сангаас хассан байна.

Мянган Төгрөгөөр	Хугацаа хэтрээгүй	30 Хүртэлх Хоногоор Хугацаа Хэтэрсэн	30-90 Хоногоор Хугацаа Хэтэрсэн	91-180 хоногоор хугацаа хэтэрсэн	181-360 хоногоор хугацаа хэтэрсэн	360-аас дээш хоногоор хугацаа хэтэрсэн	Нийт дүн
Бизнесийн Зээл	119,930,033	26,915,656	4,620,931	755,787	2,129,355	14,074,187	168,425,949
Хэрэглээний Зээл	3,039,409	65,039	-	-	-	2,706	3,107,154
Орон сууцны Зээл	26,410,394	1,137,736	-	-	-	1,192,491	28,740,620
Бусад зээл	-	-	-	-	-	-	-

Хуримтлуулж								
Тооцсон хүүгийн авлага	4,518,373	20,619,619	4,648,675	1,866,202	15,187,153	12,797,605	59,637,628	
Хасах нь:								
Эрсдэлийн сан	3,285,798	159,539	231,046	188,946	1,064,677	15,269,383	20,199,391	
Дүн	150,612,411	48,578,511	9,038,560	2,433,043	16,251,830	12,797,605	239,711,960	

Харилцагчдад олгосон зээл болон бусад санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын санг Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын дагуу үндсэн зээл болон хүүгийн төлбөрийн хугацаа хэтэрсэн хоногоор шатлал тооцож, тодорхойлдог.

7.5 Зээлийн төвлөрөл

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31-ний		2016 оны 12 сарын 31-ний	
	Дүн	үлдэгдэл Хувь (%)	Дүн	Үлдэгдэл Хувь (%)
Засгийн газарт олгосон зээл	-	0.00%	-	0.00%
Банк хоорондын захаар олгосон зээл	-	0.00%	-	0.00%
Бусад санхүүгийн байгууллагад олгосон зээл	1,740,910	1.00%	2,007,760	1.00%
Санхүүгийн бус байгууллагад олгосон Зээл		0.00%		0.00%
- Улсын байгууллага	-	0.00%	-	0.00%
- Хувийн байгууллага	150,310,379	75%	127,003,514	87%
Иргэдэд олгосон зээл	48,222,434	24%	17,528,419	12%
Өрх гэр, иргэдэд үйлчлэгч ашгийн бус байгууллага (Улс төрийн нам, сүм хийд)-д олгосон зээл	-	0.00%	-	0.00%
Эдийн засгийн харъяат бус (оршин суугч бус)	-	0.00%	-	0.00%
	200,273,723	100.00%	146,539,693	100.00%

Банкны топ 40 томоохон зээлдэгчдийн үлдэгдэл нь нийт зээлийн үлдэгдлийн 78 хувийг эзэлж байна.

8 Бусад санхүүгийн хөрөнгө

Мянган төгрөгөөр	Бусдаас авах авлага	Авлагын эрсдэлийн сан	Бусдаас авах авлага (цэвэр дүнгээр)
Эхний үлдэгдэл	709,437	(429,090)	280,347
Нэмэгдсэн	37,000,664	447	37,001,111
Хасагдсан (-)	(35,130,110)	-	(35,130,110)
Төлөгдсөн	(35,130,110)	-	(35,130,110)
Данснаас хассан	-	-	-
Эцсийн үлдэгдэл	2,579,990	(428,643)	2,151,347

9 Бусад санхүүгийн бус хөрөнгө

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Бусад тооцоо	2,306,744	1,048,518
Өмчлөх бусад хөдлөх хөрөнгө	9,410,654	149,900
	11,717,398	1,198,418

9.1. Бусад тооцоо

<i>Мянган төгрөгөөр</i>	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Улсын тэмдэгтийн хураамж	186,744	83,401
Дараагийн тайлангийн тооцоо	633,983	140,761
Урьдчилгаа	1,094,093	445,834
Бараа материал үнэ бүхий зүйлс	-	133,794
Бусад	298,396	244,729
	<u>2,213,216</u>	<u>1,048,518</u>

Бусад санхүүгийн бус хөрөнгөнд банкны төв оффисын барилгын түрээсийн барьцаанд байршуулсан мөнгөн хөрөнгө, бусад санхүүгийн бус байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгийг бүртгэсэн байна.

9.2 Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө (ӨБҮХХ)

<i>Мянган төгрөгөөр</i>	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Үл хөдлөх хөрөнгө	9,572,529	691,933
Хөдлөх хөрөнгө	-	149,900
Өмчлөх бусад санхүүгийн бус хөрөнгийн эрсдэлийн сан	(161,875)	(691,933)
	<u>9,410,654</u>	<u>149,900</u>

10 Үндсэн хөрөнгө

<i>Мянган Төгрөгөөр</i>	Барилга байгууламж	Компьютер, Дагалдах Хэрэгсэл	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Үндсэн хөрөнгийн санхүүжилт урьдчилгаа	Нийт дүн
ҮНДСЭН ХӨРӨНГӨ /өртөг/						
Эхний үлдэгдэл	9,492,665	813,377	2,454,226	1,123,466	2,841,984	16,725,718
<u>Нэмэгдсэн дүн</u>	6,616,136	192,066	520,200	194,103	-	7,522,505
Худалдаж авсан	3,216,136	192,066	520,200	194,103	-	4,122,505
Дахин үнэлгээний нэм эгдэл	3,400,000	-	-	-	-	3,400,000
<u>Хасагдсан дүн(-)</u>	3,894,788	66,829	1,113,713	12,327	921,585	6,009,243
Худалдсан	3,894,788	-	1,113,713	-	921,585	5,930,086
Акталсан	-	66,829	-	12,327	-	79,156
Эцсийн үлдэгдэл	12,214,012	938,613	1,860,713	1,305,242	1,920,399	18,238,980
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ						
Эхний үлдэгдэл	564,041	573,521	1,257,103	785,567	-	3,180,232
<u>Нэмэгдсэн дүн</u>	255,332	154,243	187,716	75,427	-	672,718
Байгуулсан элэгдэл	255,332	154,243	187,716	75,427	-	672,718
<u>Хасагдсан дүн</u>	689,176	78,356	913,535	33,941	-	1,714,578
Данснаас хассан хөрөнгийн элэгдэл	465,382	78,356	913,535	33,491	-	1,490,785
Дахин үнэлгээгээр хасагдсан	223,793	-	-	-	-	223,793
Эцсийн үлдэгдэл	130,196	649,388	531,285	827,503	-	2,138,372
ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН	-	-	-	-	-	-
Эхний үлдэгдэл	8,928,624	239,856	1,197,123	337,889	2,841,984	13,545,486
Эцсийн үлдэгдэл	12,083,816	289,225	1,329,428	477,739	1,920,399	16,100,608

Тайлант онд үндсэн хөрөнгө нийт 7,522,505 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба Дархан хот дахь орон сууц, конторын барилга, Эрдэнэт хот дахь дугуй барилга, Тэнгэр вилла орон сууц зэрэгт 3,400,000.0 мянган төгрөгийн дахин үнэлгээ хийсэн байна.

Тайлант оны элэгдлийн зардал 672,718 мянган төгрөгийг *дэлгэрэнгүй орлогын тайлангийн “Үйл ажиллагааны бусад зардал”* –д тусгасан.

11 Биет бус хөрөнгө

Мянган төгрөгөөр	Програм хангамж	Бусад биет бус хөрөнгө	Нийт дүн
Биет бус хөрөнгө /өртөг/			
Эхний үлдэгдэл	436,789	3,445	467,233
,Нэмэгдсэн дүн	497,164	40,989	538,154
Худалдаж авсан	497,164	40,989	538,154
Хасагдсан дүн (-)	-	-	-
Худалдсан	-	-	-
Эцсийн үлдэгдэл	960,953	44,434	1,005,387
Хуримтлагдсан хорогдол			
Эхний үлдэгдэл	278,204	104	278,308
Нэмэгдсэн дүн	54,739	4,862	59,602
Байгуулсан хорогдол	54,739	4,862	59,602
Хасагдсан дүн	-	-	-
Эцсийн үлдэгдэл	332,943	4,966	337,910
ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН			
Эхний үлдэгдэл	185,585	3,341	188,925
Эцсийн үлдэгдэл	628,009	39,468	667,477

Банк нь ТУЗ-ийн 2016 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн Д/10 дугаар тогтоолын дагуу Грейп Сити ХХК-ийн NES ERP систем, бусад биет бус хөрөнгийг 538,154 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

12 Харилцагчдын харилцах, хадгаламж

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31-ний Үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Харилцах дансны нэрлэсэн үлдэгдэл (*1)	138,694,211	56,327,528
Харилцах дансанд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	1,110,929	401,867
Харилцахын дүн	139,805,140	56,729,394
Хугацаагүй хадгаламж	1,149	145,606
Хугацаатай хадгаламж (*2)	77,590,000	49,673,551
Хадгаламжинд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	-	37,857
Хадгаламжийн дүн	77,591,149	49,857,014
Нийт дүн	217,396,289	106,586,409

Харилцах дансны хуримтлагдсан хүүний өглөг нь бүтээгдэхүүний төрлөөс хамаарч өдөр бүр, сарын эцэст гэх мэтээр хуримтлагддаг байна.

(*1) Харилцах дансны нэрлэсэн үлдэгдлийг харилцагчийн төрөл болон валютаар нь ангилан харуулбал:

<i>Мянган төгрөгөөр</i>	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Олон улсын гэрээнд банкинд данс нээхээр заасан олон улсын санхүүжилтээр хэрэгжиж байгаа төсвийн байгууллагын данс	3,411,954	-
Улсын болон орон нутгийн төсвийн байгууллагын данс	327,639	-
Нийгмийн даатгалын сангийн данс	48,246,863	12,152,642
Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын данс	3,387,682	-
Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн данс	2,354,482	2,851,702
Хувьцаат компани	6,815,322	2,465,457
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	17,794,163	8,082,968
Нөхөрлөл	20	19
Бусад	289,520	1,480,124
Иргэд Өрх гэр, иргэдэд үйлчлэгч ашгийн бус байгууллага (Улс төрийн нам, сүм хийд)	19,533,088	6,938,706
Эдийн засгийн харъяат бусын (Гадаадын оршин суугч бусын)	5,876	49,579
	102,167,173	34,021,987
<i>Гадаад валютын</i>		
Олон улсын гэрээнд банкинд данс нээхээр заасан олон улсын санхүүжилтээр хэрэгжиж байгаа төсвийн байгууллагын данс	6,003,500	-
Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн данс	18,905,933	1,148,296
Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын данс	670,336	1,499,161
Хувьцаат компани	2,436,536	9,874
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	191,164	1,207,622
Бусад	428,752	53
Иргэд Өрх гэр, иргэдэд үйлчлэгч ашгийн бус байгууллага (Улс төрийн нам, сүм хийд)	4,833,273	16,633,350
Эдийн засгийн харъяат бусын (Гадаадын оршин суугч бусын)	34	82
	3,057,509	1,807,103
	36,526,987	22,305,541
	138,694,211	56,327,528

(*2) Хугацаатай хадгаламж дансны үлдэгдлийг харилцагчийн төрөл болон валютаар нь ангилан харуулбал:

<i>Мянган төгрөгөөр</i>	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Нийгмийн даатгалын сан /төгрөгийн/	77,590,000	48,000,000
Эдийн засгийн харъяат бус (гадаадын оршин суугч бусын) /гадаад валют/	-	1,673,551
	<u>77,590,000</u>	<u>49,673,551</u>

13 Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр

	2017 оны 12 сарын 31-ний Үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний Үлдэгдэл
<i>Мянган төгрөгөөр</i>		
Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах(*1)	49,260,259	29,640,961
Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан хадгаламж(*2)	49,113,565	45,429,595
Монголбанкны овернайт зээл	-	10,000,000
Монгол банкнаас авсан төслийн зээл	2,904,752	-
Бусад санхүүгийн байгууллагаас авсан зээл	9,830,007	-
Орон сууцны ипотекийн зээл		3,667,800
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн Өглөг	345,535	345,056
	111,454,118	89,083,412

(*1) Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах дансыг байгууллагын төрлөөр задалж харуулбал:

Харилцах	2017 оны 12 сарын 31-ний Үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний Үлдэгдэл
Хөгжлийн банк	37,882,331	19,423,897
Даатгал ХХК	2,621,366	4,803,120
Банк бус санхүүгийн байгууллага	-	418,366
Хадгаламж банк /банкны эрх хүлээн авагч/	-	4,978,258
Үнэт цаасны компани	3	21
Бусад санхүүгийн байгууллага	8,756,541	17,299
	49,260,241	29,640,961

(*2) 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх хадгаламжийн үлдэгдэл дараах байдлаар задарч байна. Үүнд:

Гэрээний Дугаар	Хадгалуул агч банк	Валют	Эхлэх Огноо	Дуусах огноо	Хугацаа	Хүү /жилээр/	Үлдэгдэл /мян.ам. доллар/	Үлдэгдэл /мянган төгрөг/
Хадгаламж								
БХХ2017/12/04-1/2/787	ҮХОБанк Хөгжлийн банктөгрөг	төгрөг	2017/12/04	2018/06/04	182	14%	-	2,000,000
			2017/12/07	2018/01/04	28	12%	-	8,700,000
БХХ2017/12/11-1/2/826	ҮХОБанк Хөгжлийн банктөгрөг	ам.доллар	2017/12/11	2018/01/11	31	7%	500	1,213,565
2/825	Хөгжлийн банктөгрөг		2017/12/18	2018/01/02	15	12%	-	5,000,000
2/873	Хөгжлийн банктөгрөг		2017/12/19	2018/01/03	15	12%	-	5,000,000
2/875	Хөгжлийн банктөгрөг		2017/12/20	2018/01/05	16	12%	-	4,500,000
2/874	Хөгжлийн банктөгрөг		2017/12/21	2018/01/08	18	12%	-	3,000,000
2/874	Хөгжлийн банктөгрөг		2017/12/22	2018/01/09	18	12%	-	5,000,000
2/893	Хөгжлийн банктөгрөг		2017/12/26	2018/01/11	16	11%	-	5,000,000
2/894	Хөгжлийн банктөгрөг		2017/12/25	2018/01/10	16	11%	-	5,000,000
2/892	Хөгжлийн банктөгрөг		2017/12/28	2018/01/12	15	11%	-	4,700,000
								49,113,565

(*3) Орон сууцны ипотекийн зээл

Монголбанкнаас баталсан “Орон сууцны ипотекийн зээлийн журам”-ын дагуу тус банк болон Монголбанкны хооронд 2013 оны 6 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан “Монголбанкнаас банкинд олгох орон сууцны ипотекийн санхүүжилтийн гэрээ”-ээр тус банкинд орон сууцны ипотекийн зээлийн эх үүсвэрийг олгох, уг эх үүсвэрээр банк журмын дагуу орон сууцны ипотекийн зээл шинээр олгох, өмнө олгосон зээлийг дахин санхүүжүүлэх, санхүүжилтийн эх үүсвэрээр бий болсон зээлийг МИК-д худалдаж, МИК-иас Ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ) худалдан авах, зээлийн эх үүсвэрийг ИЗББ-оор Зээлдүүлэгчид буцаан төлөх зэрэг үйл ажиллагааг зохицуулахаар тохирсон.

Гэрээний дагуу орон сууцны ипотекийн зээл шинээр олгох эхлэлийн санхүүжилт 715,000,000 төгрөгийг 9 сарын хугацаатайгаар, өмнө нь олгосон орон сууцны ипотекийн зээлийг дахин санхүүжүүлэх эхлэлийн санхүүжилт 3,576,000,000 төгрөгийг 6 сарын хугацаатайгаар, жилийн 4%-н хүүтэйгээр нийт 4,291,000,000 төгрөгийг тухайн хугацаанд олгосон. Уг гэрээний нэмэлтээр 2014 оны 12 дугаар сарын 5-ны өдөр 6,000,000,000 төгрөгийн санхүүжилтийг Монголбанкнаас тус банкинд нэмж олгосон.

Мөн 2017 онд Монголбанк, Засгийн газар, банкны хооронд байгуулсан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийн гэрээ”-ний дагуу нийт 1,684,121,222 төгрөгийн (Монголбанкнаас: 1,171,522,181 төгрөг; Засгийн газраас: 512,569,041 төгрөг) эх үүсвэрийг олгосон ба банкнаас 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 1,934,600,000 төгрөгийн эх үүсвэрийг буцаан төлсөн байна.

Банк болон Монголбанкны хооронд 2013 оны 6 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан “Монголбанкнаас банкинд олгох орон сууцны ипотекийн санхүүжилтийн гэрээ”-ний хугацааг 2016 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн №0313/300-08 тоот гэрээгээр 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдөр хүртэл сунгасан байсан ба уг гэрээг 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн №0313/300-09 тоот гэрээгээр 2019 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл сунгасан.

Ипотекийн зээлийн эх үүсвэрийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл 3,417,321,222 төгрөг (2016.12.31: 3,667,800,000 төгрөг) байна.

14 Бусад эх үүсвэр

<i>Мянган төгрөгөөр</i>	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Төслийн зээлийн санхүүжилт	12,041,925	37,952,085
Хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр	18,136,874	9,996,175
Бусад	5,511,392	567,970
Бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	24,083	47,093
	<u>35,714,275</u>	<u>48,563,323</u>

*1) Төслийн зээлийн санхүүжилт

<i>Мянган төгрөгөөр</i>	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Барилгын салбарыг дэмжих, орон сууцны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн зээлийн эх үүсвэр	-	659,370
Ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийг дэмжих төслийн эх үүсвэр	-	8,830,000
Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих сангийн эх үүсвэр	-	1,769,852
Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих сангийн эх үүсвэр	2,221,093	4,059,997
Экспортыг дэмжих, импортыг орлох дотоодын үйлдвэрлэлийг дэмжих төслийн зээл	8,035,373	10,934,809
Гүн боловсруулах зорилгоор арьс шир худалдаж авах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тоног төхөөрөмж шинэчлэхэд зориулагдсан зээл	9,830,007	11,698,057
	<u>20,086,473</u>	<u>37,952,085</u>

Ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийг дэмжих төслийн эх үүсвэр

Засгийн газрын 2011 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн “Ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, ноос боловсруулах үндэсний үйлдвэрлэгчийг Засгийн газрын бондын эх үүсвэрээр дэмжих хөрөнгийг зарцуулах, хяналт тавих, тайлагнах журам”-ын дагуу

Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээр нэмэгдсэн өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газраас гаргасан бондын эх үүсвэрээр бүрдэх хөрөнгөөс Ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд 100,000,000 мянган төгрөгийн, ноос боловсруулах үндэсний үйлдвэрлэгчдэд 30,000,000 мянган төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгоход зориулан, Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам болон ЧИНГИС ХААН БАНКны хооронд 2011 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр “Засгийн газраас гаргасан бондын эх үүсвэрээр бүрдэх хөрөнгийн дамжуулах зээлдүүлэлтийг хамтран хэрэгжүүлэх гэрээ”-г байгуулсан.

Гэрээний дагуу ХХААХҮ-ийн сайдын шийдвэрээр байгуулагдсан Зохицуулах зөвлөлийн хуралдаанаар дэмжигдсэн төслүүдэд хөнгөлөлттэй зээл олгох бөгөөд ноолуурын чиглэлээр нэг үйлдвэрт олгох зээлийн дээд хэмжээ 10,000,000 мянган төгрөг, ноосны чиглэлээр 5,000,000 мянган төгрөгөөс ихгүй, 5 хүртэлх жилийн хугацаатай, хүүгийн түвшин жилийн 7 хувиас хэтрэхгүй, үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх доод хугацаа 1 жил, зээлийн үйлчилгээний шимтгэлгүй байх нөхцөлөөр олгоно.

Банк нь олгосон зээлийн эрсдэлийг 100 хувь бие даан хариуцах бөгөөд зээлийн эх үүсвэрээс сар бүр 0,05 хувиар тооцож, хяналт тавих, зөвлөгөө өгөхөд зориулсан төлбөрийг улирал бүрийн дараа сарын 10-ны дотор ЖДҮХСанд шилжүүлнэ. Зээлийн хүүний орлогоос энэхүү хяналтын төлбөрийг хассан дүн нь банкны орлого байна.

Төслийн зээлийн эх үүсвэрийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх үлдэгдэлгүй (2016.12.31: 8,830,000 мянган төгрөг) байна.

Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих сангийн эх үүсвэр

Монгол улсын их хурлын 2010 оны 6 дугаар сарын 25-ны өдөр баталсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх, түүнийг санхүүжүүлэх зорилгоор Засгийн газрын 2012 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 138 дугаар тогтоолын дагуу Монгол улсын Хөгжлийн банк, Хөдөлмөрийн яам болон ЧИНГИС ХААН БАНК ХХК-ийн хооронд “Гурван талт гэрээ”-г 2013 оны 5 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан.

Уг гэрээгээрх зээлийн эх үүсвэрээр “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих замаар ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрт хөнгөлөлттэй нөхцлөөр зээл олгох ба “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор арилжааны банкаар дамжуулан хөрөнгөлөлттэй зээл олгох төслийг сонгон шалгаруулах дэд комиссын үйл ажиллагааны журам”-ын дагуу сонгогдсон төсөл, хөтөлбөрүүдэд олгох зээлийн нийт хэмжээ 5,000,000 мянган төгрөг хүртэл байна. Хөнгөлөлттэй зээлийг 2017 оныг дуустал, жилийн 7 хувийн хүүтэй, зээлийн эхний олголтоос хойш 12 сарын (2013.09.26-ны өдрийн 2013/01/01 тоот нэмэлт гэрээгээр 6 сар байсныг 12 сар болгон өөрчилсөн) хугацаанд үндсэн төлбөрөөс чөлөөлөх нөхцөлтэйгээр олгоно.

Банк нь олгосон зээлийн эрсдэлийг 100 хувь бие даан хариуцах бөгөөд зээлийн эх үүсвэрээс сар бүр 0.15 хувиар тооцож, хяналт тавих, зөвлөгөө өгөхөд зориулан улирал бүрийн дараа сарын 10-ны дотор ЖДҮХСанд шилжүүлнэ. Зээлийн хүүний орлогоос энэхүү хяналтын төлбөрийг хассан дүн нь банкны орлого байна.

Төслийн зээлийн эх үүсвэр 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх үлдэгдэлгүй (2016.12.31: 1,769,852 мянган төгрөг) байна.

Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих сангийн эх үүсвэр

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 6 дугаар сарын 10-ны өдөр баталсан “Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл” тогтоол болон 2009 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр баталсан “Монгол улсын үйлдвэржүүлэх хөтөлбөр”-ийн дагуу орон нутагт жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх нөөц, боломж дээр тулгуурласан үйлдвэрлэл, үйлчилгээг санхүүжүүлэх механизмыг бий болгох, санхүүгийн таатай орчныг төрийн байгууллагуудын оролцоотойгоор бүрдүүлэх, улмаар орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх, хүн амын

амьжиргааны төвшинг дээшлүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангахад зориулан олгох зээлийг санхүүжүүлэх зорилгоор “Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ) болон ЧИНГИС ХААН БАНК ХХК-ийн хооронд 2011 оны 12 дугаар сарын 19-ний өдөр “Хамтран ажиллах гэрээ” байгуулсан.

Уг гэрээгээр ХХААХҮЯ-амны төсөл сонгон шалгаруулах комиссын хуралдаанаас сонгогдсон төслүүдэд олгохоор шийдвэрлэсэн зээлийн хэмжээгээр жилийн 8 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатайгаар 1 хүртэлх жилээр зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөх нөхцөлтэйгээр төсөл хэрэгжүүлэгчид олгоно.

Банк нь улсын төсвийн санхүүжилтээс зээлийн зориулалтаар гаргасан мөнгөн дүнгээс сар бүр 0.1 хувийн хяналтын зардал буюу хөнгөлөлттэй зээл олгохыг зохион байгуулах, хяналт тавих, сургалт зөвлөгөө өгөхөд зориулан ЖДҮХСанд төлөх бөгөөд зээлийн хүүний орлого нь банкны орлого байна.

Төслийн зээлийн эх үүсвэрийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл 2,221.1 сая төгрөг (2016.12.31: 4,060.0 сая төгрөг) байна.

Экспортыг дэмжих, импортыг орлох дотоодын үйлдвэрлэлийг дэмжих төслийн зээл

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 239 дугаар тогтоолоор баталсан “Экспортыг дэмжих хөтөлбөр” болон 2016 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 176 дугаар тогтоолоор баталсан “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын дагуу Экспортыг дэмжих, импортыг орлох дотоодын үйлдвэрлэлийн 2 тэрбум төгрөгөөс илүүгүй зээл хүссэн төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор 2014 оны 8 дугаар сарын 8-ны өдөр Монгол Улсын Хөгжлийн банк, Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан болон ЧИНГИС ХААН БАНК ХХК-ийн хооронд “Гурван талт зээлийн гэрээ” байгуулсан.

Гэрээгээр Хөгжлийн банк нь Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан (ЖДҮХС)-д төслийг санхүүжүүлэх нийт 100,000,000 мянган төгрөгийг шилжүүлэх ба ЖДҮХС нь дэд зээлийн эх үүсвэрийг банкинд шилжүүлж, банк нь Хөдөлмөрийн яамны төсөл сонгон шалгаруулах комиссын баталсан төслүүдэд 5 хүртэлх жилийн хугацаатай, жилийн 7 хувийн хүүтэйгээр олгоно.

Банкинд олгосон төслийн зээлийн эх үүсвэр нь жилийн 3 хувийн хүүтэй, 5 хүртэлх жилийн хугацаатай байна.

Төслийн зээлийн эх үүсвэрийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл 8,035,372 мянган төгрөг (2016.12.31: 10,934,809 мянган төгрөг) байна.

Гүн боловсруулах зорилгоор арьс шир худалдаж авах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тоног төхөөрөмж шинэчлэхэд зориулагдсан зээл

Монгол Улсын их хурлын 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 74 дүгээр тогтоолд үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2013 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 48 дугаар тогтоолоор “Арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох, хяналт тавих, тайлагнах журам”-ыг баталсан ба энэхүү журмын дагуу Монгол Улсын Хөгжлийн банк болон ЧИНГИС ХААН БАНК ХХК-ийн хооронд 2014 оны 7 дугаар сарын 24-ний өдөр “Дамжуулан зээлдүүлэх гэрээ” байгуулсан.

Хөгжлийн банкнаас банкинд олгох зээлийн нийт хэмжээ нь 110,400,000 мянган төгрөг (дэд зээлүүдийн нийлбэр дүнгээр тодорхойлогдоно) бөгөөд 5 хүртэлх жилийн хугацаатай, жилийн 5 хувийн хүүтэй байна.

Гэрээний дагуу төсөл хэрэгжүүлэгчид олгох зээлийн эх үүсвэрийг банкнаас ирүүлсэн шийдвэр, зээл шилжүүлэн авах албан хүсэлт болон бусад баримт бичгийг үндэслэн, Хөгжлийн банкнаас тус банкинд олгох ба банк нь дэд зээлийг 5 хүртэлх жилийн хугацаатай, жилийн 7 хүртэлх хувийн хүүтэйгээр төсөл хэрэгжүүлэгчид олгоно.

Дамжуулан зээлдэх гэрээний эх үүсвэрийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл нь 9,830,000 мянган төгрөг (2016.12.31: 11,698,057 мянган төгрөг) байна.

(*2) Үнэт цаасны арилжааны эх үүсвэр

2016 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр Чингис хаан банк болон Хадгаламжийн даатгалын корпораци хооронд ХЗХ 2016/11/01-1 тоот Хөрөнгө оруулалтын зуучлалын гэрээг байгуулсан. Уг гэрээнд Чингис хаан банк нь Хадгаламжийн даатгалын корпорацийн эх үүсвэрээр Төвбанкны үнэт цаас худалдан авах, түүнийг буцаан төлөх нөхцлийг тодорхойлсон. 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 18,136,874 мянган төгрөгийг (2016.12.31: 9,996,175 мянган төгрөг) тус банкинд байршуулсан байна.

(*3) Баталгаа, батлан даалт эх үүсвэр

Батлан даалтын эх үүсвэр нь харилцагчийн өмнөөс гуравдагч этгээдэд банкны гаргасан баталгаа, батлан даалтын барьцаанд тусгаарласан мөнгийг илэрхийлнэ.

15 Бусад санхүүгийн өр төлбөр

<i>Мянган төгрөгөөр</i>	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Дансны өглөг	353,256	182,529
Банк, салбар хоорондын тооцоо	312,908	72,071
Мөнгөн гуйвуулгын өглөг	93	73,835
Ногдол ашгийн өглөг	274,284	274,283
Картаар үйлчлэгч байгууллагуудын өглөг	508,872	318,334
	<u>1,449,413</u>	<u>921,052</u>

16 Бусад санхүүгийн бус өр төлбөр

<i>Мянган төгрөгөөр</i>	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын өглөг	-	5,148
Бусад татварын тооцоо	20,344	4,485
	<u>20,344</u>	<u>9,633</u>

17 Өөрийн хөрөнгө, түүний удирдлага

17.1. Өмчийн хэлбэр

<i>Мянган төгрөгөөр</i>	Дүн	Эзлэх хувь (%)
Хувийн	47,983,740	100%
	<u>47,983,740</u>	<u>100%</u>

17.2. Хувь нийлүүлсэн хөрөнгө

Мянган төгрөгөөр	Эргэлтэнд байгаа бүрэн төлөгдсөн энгийн хувьцаа		
	Тоо ширхэг	Нэгжийн нэрлэсэн үнэ	Дүн
Эхний үлдэгдэл	39,373,246	1000	39,373,246
Нэмэгдсэн	8,610,494	1000	8,610,494
Хасагдсан (-)	-	-	-
Эцсийн үлдэгдэл	47,983,740	1,000	47,983,740

